

## **Товч танилцуулга**

Монгол Улс, Дэлхийн банкны Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк болон Олон улсын хөгжлийн ассоциаци хоорондын "Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төсөл"-ийн Зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийн талаар

### **1. Ерөнхий агуулга, зохицуулах харилцаа, зарчмын шинжтэй зохицуулалт:**

Уг хуулийн төсөл нь 1 зүйлтэй.

Хуулийн төсөлд Монгол Улс, Дэлхийн Банкны Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк болон Олон улсын хөгжлийн ассоциаци хооронд 2023 оны 08 дугаар сарын 28-ны өдөр байгуулсан "Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төсөл"-ийн Зээлийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлахаар тусгасан.

Энэхүү "Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төсөл"-ийн Зээлийн хэлэлцээр нь Олон улсын гэрээний тухай хуулийн 8.1.2-т заасан "гадаад улс, олон улсын байгууллага, гадаад улсын болон олон улсын банк, санхүүгийн байгууллагаас авах зээлийн ерөнхий нөхцөлийн талаархи олон улсын гэрээ"-нд хамаарах тул Улсын Их Хурал соёрхон батлах хуулийн зохицуулалттай болно.

### **2. Тухайн харилцааг урьд нь хууль, эрх зүйн бусад актаар зохицуулж ирсэн байдал:**

Монгол Улс, Дэлхийн Банкны Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк болон Олон улсын хөгжлийн ассоциаци хооронд 2023 оны 08 дугаар сарын 28-ны өдөр байгуулсан "Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төсөл"-ийн Зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах харилцаа тул тус харилцааг урьд нь хууль, эрх зүйн актаар зохицуулаагүй болно.

### **3. Хуулийн төслийг боловсруулахтай холбогдуулан хууль санаачлагчаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:**

Төслийг хэрэгжүүлэгч төрийн захиргааны төв байгууллагууд хамтран тус төслийн Зээлийн хэлэлцээрийг 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр хийсэн.

### **4. Хуулийн төслийг олон нийтээр хэлэлцүүлсэн дүн:**

Монгол Улс, Дэлхийн Банкны Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк болон Олон улсын хөгжлийн ассоциаци хоорондын "Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төсөл"-ийн Зээлийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын хуралдаан, Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодын хуралдаанаар хэлэлцүүлэн, зөвшилцсөний үндсэн дээр байгуулсан болно.

### **5. Гадаад орны туршлага, бусад судалгаа, шинжилгээний тайлангийн дүгнэлт:**

Уг хуулийн төсөлд тусгасан Монгол Улс, Дэлхийн банкны Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк болон Олон улсын хөгжлийн ассоциаци хооронд 2023 оны 08 дугаар сарын 28-ны өдөр байгуулсан "Монгол Улсын тээврийн холболт болон

логистикийг сайжруулах төсөл"-ийн Зээлийн хэлэлцээрийн хүрээнд Дэлхийн банкнаас Ерөнхий нөхцөлийн гарын авлага болон хэрэгжүүлэхтэй холбоотой бусад судалгааг хийсэн.